

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2021.03.25-2021.04.23/

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сумын Засаг дарга аймгийн Засаг даргатай 2021 онд хамтран ажиллах гэрээгээ байгуулсанаар сумын төсвийн 5 байгууллагын удирдлага болон Засаг даргын орлогч, багийн Засаг дарга нартай “Хамтран ажиллах гэрээ”-гээ байгуулсан.



Илчлэг шивээ ОНӨҮГ-ын хуучирч муудсан зуухыг сольж шинээр 2,3 мвт-ын хүчин чадалтай 2 зуухыг Улсын төсвийн 300 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлж суурилуулах ажлын гүйцэтгэл 80 хувьтай хийгдэж байна.




Корона вирусээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд: Аймгийн Засаг даргын 2021 оны А/90 дүгээр бүх нийтийн бэлэн байдлын зэрэг “Улаан түвшин”-д шилжсэн захирамжийг хэрэгжүүлэхээр сумын Засаг даргын А/49 дүгээр захирамжийг гарган дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

Сумын 22-р зөрлөгийн гарман дээр нэг хяналтын пост 24 цагаар 8 байгууллагын 30 албан хаагч хуваарийн дагуу ажиллаж сумруу орж гарах тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавин ажиллаж байна.

Мөн төмөр замын 5 нүхэн гарцыг хааж хулгайн тээврийн хэрэгсэл явах нөхцлийг таслан зогсоосон.



Нийтийн эзэмшлийн гудамж талбай, хүүхдийн тоглоомын талбай бүхий 23 цэгийн 72600 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн 2 банк, хүнсний худалдаа эрхэлдэг 10 дэлгүүрт агаарын ариутгал хийсэн.



Суманд ойрын хавьталын 15 хүн, түүний гэр бүлийн 25 гишүүн, Улаанбаатар хотоос ирсэн 12 иргэн, гэр бүлийн 2, нийт 54 иргэн гэрийн ажиглалт, тусгаарлалтанд байна. Гэрийн ажиглалт, тусгаарлалтанд байгаа иргэдээр баталгааны хуудсыг бөглүүлж баталгаажуулан гэрийнх нь хаалгыг лацдах ажлыг зохион байгуулсан.

Сум дотор хөдөлгөөнт эргүүлд 4 машины 12 алба хаагч, явган эргүүлд сургууль, цэцэрлэгийн багш нар ээлжээр өдөрт 4 хүний бүрэлдэхүүнтэй эргүүл хяналтын ажлыг хийж гүйцэтгэж байна.

Сумын штабт ЗДТГ-ын албан хаагчид хуваарийн дагуу жижүүрлэн мэдээ, тайланг цаг хугацаанд нь гаргаж, хүргүүлэн ажиллаж байна.

Иргэдийн сум хооронд нэвтрэх зөвшөөрлийг сумын Засаг даргын орлогч олгож өнөөдрийн байдлаар 36 иргэн зөвшөөрөл авсны дийлэнх хувийг 13а маягтаар олгосон байна. Энэ нь манай суманд шүдний эмч байхгүйтэй холбоотойгоор шүдний эмчид үзүүлэхээр зөвшөөрөл авч буй иргэдийн тоо ихэнх хувийг эзэлж байна.

ТӨСӨВ САНХҮҮ

2021 оны 04-р сарын 23-ны байдлаар орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл өссөн дүнгээр дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /мянган.төг/	Зардлын гүйцэтгэл /мянган.төг/
1.	ИТХ	31468.5	27123.5
2.	ЗДТГ	163344.0	145949.3

Төвлөрсөн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /мянган.төг/	Зардлын гүйцэтгэл /мянган.төг/
1.	Эрүүл мэндийн төв	1641974.2	149510.7
2.	Соёлын төв	41535.2	32615.2
3.	3-р сургууль	342728.2	317760.9
4.	3-р цэцэрлэг	202657.9	161928.7

2021 оны 04 -р сарын 23-ны өдрийн байдлаар орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 51 352.0 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэл 82 468.4 мянган төгрөг буюу 160 хувийн биелэлттэй байна.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Төрийн цахим үйлчилгээний 52 нэр төрлийн лавлагаа, тодорхойлолтыг 04 дүгээр сард өссөн дүнгээр 92 иргэнд олгосоноор иргэд аймаг орохгүйгээр сумаасаа цахим төрийн үйлчилгээг аваад байна.

Суманд наториатын үйлчилгээг иргэдэд үзүүлж 4-р сарын 23-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 65 иргэнд үйлчилгээг үзүүлж 135000 төгрөгийн орлогыг сумын тэмдэгтийн хураамжийн дансанд төвлөрүүлсэн байна.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ


3-Р СУРГУУЛЬ :

Говьсүмбэр аймагт “КОВИД 19” цар тахлын шинэ халдвар илэрсэн тул танхимаар хичээллэж байсан сургалтын үйл ажиллагааг Аймгийн онцгой комиссын шийдвэрээр зогсоож, 3 сарын 29-ний өдрөөс 4 сарын 5-ны өдөр хүртэл хоёрдугаар улирлын сурагчдын амралт хэлбэрт шилжүүлж, хөл хорио тогтоосоэ.

4 сарын 5-ны өдрөөс 3 дугаар улирлын сургалтын үйл ажиллагаа теле болон цахим, зайн сургалт /танхимын бус хэлбэр/-аар эхэллээ. Энэ хугацаанд сурагчид хуваарийн дагуу теле хичээлээ үзэж, тэмдэглэлээ илгээхээс гадна анги удирдсан болон мэргэжлийн багш нарын гаргасан хуваарийн дагуу цахим хичээлд хамрагдаж байна. Мөн теле болон цахим хичээлд хамрагдах боломжгүй зорилтот бүлгийн суралцагчидтай зайн сургалтын хэлбэрээр хэвлэмэл материал хүргүүлэн, эргэх холбоо тогтоон ажиллаж байна.

Танхимын бус сургалтын үйл ажиллагааны өмнөх өдрийн үр дүнг өдөр бүр Боловсролын газарт илгээж байна.

Тоон мэдээг харьцуулбал:



Суралцагчдынхаа гэртээ байх цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хүүхдээ гэрийн нөхцөлд хөгжүүлэх боломжийг эцэг эхэд олгох зорилгоор 4 дүгээр сарын 7 хоног бүрийг зорилготой болгон, ажиллаж байна. Үүнд:

I – 7 хоногийн “Хөгжимт хөдөлгөөн”-д 241 суралцагч хамрагдсан нь нийт сурагчийн 55,6 % байсан бол II – 7 хоногт “Уншсан номоо танилцуулах” аянд 270 суралцагч хамрагдаж, нийт сурагчийн 61.4%-ийг эзэлж, хамрагдалт өссөн байна.


3-Р ЦЭЦЭРЛЭГ

Цэцэрлэгийн нийт хүүхдүүдийн 86% нь цахим болон теле хичээлд хамрагдаж байна. Үүний 16% буюу 47 хүүхэд зайны сургалт, 70% буюу 207 хүүхэд цахим болон теле хичээлд хамрагдаж байна.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд эцэг эхчүүд хамтран ажиллаж байна. Доорх сэдвийн дагуу цахим сургалтыг бүлгийн багш нар амжилттай зохион байгуулж байна. Үүнд:

- Бага бүлэг-Тоглоом
- Дунд бүлгүүд- Гэрийн тэжээмэл амьтад, Хоёр найз
- Ахлах бүлгүүд- Бяцхан малчид, малчны хот, Таван хошуу мал төсөлт тоглоом
- Бэлтгэл бүлгүүд-Таван хошуу мал төсөлт тоглоомыг танхимын болон цахим сургалтаар хэрэгжүүлж байна.

Сургалтын явцад зайны сургалтанд хамрагдаж буй 47 хүүхдүүдэд даалгаврын ном боловсруулан түгээж хүүхдийн хөгжлийг дэмжин ажилласан.



Багшийн хөгжил- сургалтын үр дүнгийн хэлэлцүүлгийн тухайн сар бүрийн 25-нд хийдэг болсон нь сургалтын үйл ажиллагааны төлөвлөлтийн боловсруулалт, хэрэгжүүлэлт, хамрагдалтын хувь нэмэгдсэн болно.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ:

Эрүүл мэндийн төвд 16 өвчтөн хэвтэж, үүнээс 3 хүүхэд, 1 төрөлт, дотор 12 хэвтэн эмчлүүлсэн байна.

- Амбулаторийн үзлэг -428 томуу-23
- Урьдчилан сэргийлэх – 781
- Дуудлага-126
- PCR-417
- Хурдавчилсан-345



Улаанбаатар хот болон Дорноговь аймаг руу PCR шинжилгээг зөөвөрлөн ажиллаж байна.

Стратегийн ач холбогдол бүхий байгууллага болон зорилтот бүлгийн иргэдийг коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын эхний тунг тарих ажлыг 04 сарын 04-6-ны хооронд зохион байгуулж 8 байгууллагын нийт 674 ажилтанд хийж ажилласан байна. Тус үйл ажиллагааг ШОХК-тай хамтран дархлаажуулалт хийх байрыг түр зааварын дагуу бэлтгэн аймгийн мэргэжлийн хяналтын газраар үнэлгээ хийлгэн ажилласан.



Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 6 төрлийн 7ш тоног төхөөрөмжийг 04 сарын 05-ны өдөр хүлээлгэн өгсөн. Үүнд: Ариутгалын автоклав-1, пульсоксометр-1, отсос-2, хяналтын монитор-1, автомат дуслын шахуурга-1, судас тодосгогч-1 нийт 11836000 төгрөгийн тоног төхөөрөмж, 10 төрлийн 13941813 төгрөгийн нэг удаагийн хамгаалах хэрэгслийн хүлээн авсан.



УЛСЫН БҮРТГЭЛ

Иргэний бүртгэлийн үйлчилгээг 35 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 4 иргэнг бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.

4-р сард газраа анх удаа өмчилж авч байгаа 5 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг олгосоноор нийт 24 иргэн газар өмчлөлийн гэрчилгээг аймаг орохгүйгээр сумаасаа аваад байна. Иргэдээс энэ сард 19 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэсэн.

Иргэний гэр бүл байдлын статистик мэдээ тайлан болон Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэт цаасны тайлан, үнэт цаасны орлогын тайлан зэргийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2021 ОНЫ 04 САРЫН МЭДЭЭ

Шивээговь

	м/д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	32				32	21	11
Төрсөн эх	2	31				31		31
Бүртгүүлсэн гэр бүл	3	2				2	2	2
Нас баралт	4	5				5	4	1
Цуцалсан гэр бүл	5	2				2	2	2
Үрчлэгдсэн хүүхэд	6	1				1	-	1
Аймаг, нийслэлээс ирсэн шилжин	7	77				77	39	38
Аймаг, нийслэл рүү явсан шилжин	8	-				-	-	-

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС
ОРСОН ОРЛОГО**

2021.04.23.


д/д	Үйлчилгээний нэр төрөл	2021 оны 04-р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 300200022101 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
1	Нийслэлээс шилжин ирсэн	5000	1	5000	1000	1	1000	
2	Өөр аймгаас шилжин ирсэн	2500	3	7500	1000	3	3000	
3	Лавлагаа	5000	1	5000				
Дүн		17500			4000			
д/д	Үйлчилгээний нэр төрөл	2021 оны 04-р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 300200022130 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
4	Иргэний үнэмлэх	15000	4	60000	3300	4	13200	
Дүн		60000			13200			
Нийлбэр дүн		77500			17200			
Нийт орлогын дүн		94700						

НИЙГМИЙН БОДЛОГО

Японы хүүхдийг ивээх сантай хамтран хэрэгжүүлж буй энтрперенершипт суурилсан хувь хүний ур чадварыг хөгжүүлэх сургалт онлайн-ар хичээллэж эхэллээ. Сургалтанд ерөнхий боловсролын сургуулийн 8-12 ангийн сурагчдийн 2 ангийн 48 хүүхэд, насанд хүрэгчдийн ангийн 13 хүүхэд хамрагдаж байна.



Засгийн газрын 96-р тогтоол “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр 3”- г хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2021 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж “Шивээговьчууд монгол бичигтэн” нэртэй 105 гишүүнтэй цахим группыг нээж цахим сургалтуудыг оруулж монгол бичгийн мэдлэгийг сэргээх, түгээн дэлгэрүүлэх, иргэдийн монгол бичгийн мэдлэгийн түвшин тогтоох ажлуудыг зохион байгуулж байна. 4-р сард 111 иргэний мэдлэгийн түвшинг тогтоогоод байна.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Хиймэл шүд хийлгэсэн 2 ахмад настанд 260000 төгрөгийн хөнгөлөлт, бүрэн хараагүй 6 иргэнд 120000 төгрөгийн харилцаа холбооны зарлыг олгосон байна.




Хүнсний бүтээгдэхүүн олгох гэрээ байгуулсан дэлгүүрээр дамжуулан 4-р сарын 968000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг 14 өрхийн 81 гишүүнд халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн олгож, 14 өрхийн картыг пин коджуулах ажлыг зохион байгуулсан.

Шивээговь суманд ажиллаж амьдарч байгаад Улаанбаатар хот руу шилжсэн Нямдорж овогтой Наранцацрал нь 2021 оны 4-р сарын 09-ний өдөр зорилтод бүлгийн 20 өрхөд 1 сая төгрөгийн хүнсний болон хувцасны тусламж үзүүллээ.



“Хямралыг урьдчилан харж, бэлтгэлтэйгээр даван туулья-ХАБЭА-н тогтолцоог бэхжүүлье” уриан дор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2021 арга хэмжээг цахим хуудсаар дамжуулан иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулж байна. Мөн тус аяны хүрээнд Шивээ-Овоо ХК-ийн ХАБ хэлтэстэй хамтран сумын нийт төрийн албан хаагчдын дунд "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх ойлголт", "Аюул, осол гэмтэл"

сэдвээр цахим сургалтыг 2021 оны 04-р сарын 15-ны өдөр зохион байгуулан 94 албан хаагч хамрагдлаа.



БАЙГАЛЬ ОРЧИН

Сумын нийтийн их цэвэрлэгээг 3 удаа зохион байгуулж 5 ААНБайгууллагын 113 ажилтан албан хаагчид, иргэд 6 га талбайн 12 тн хог хаягдал, шороон шуурганы улмаас үүссэн элсийг ачиж төв хогийн цэгт төвлөрүүлсэн. Мөн Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаа, ШОХК-тай хамтран худгуудын тоолуурыг баталгаажуулхад хяналт тавин ажилласан.



Орчны бохирдлоос шалтгаалсан халдварт өвчлөл тархах эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сэг зэм устгалын ажлыг зохион байгуулж Орчны бохирдлоос шалтгаалсан халдварт өвчлөл тархах эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сэг зэм устгалын ажлыг 4 дүгээр сарын 7,8,9-ний өдрүүдэд зохион байгуулж, нийт 1275 сэг зэгийг 3-н цэгт халдваргүйжүүлэлт хийж булж устгасан.



МАЛ ЭМНЭЛЭГ, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСАГ

Мал төллөлт, төл бойжилтын мэдээ: нийт 26477 хээлтэгч төллөхөөс 16661 хээлтэгч төллөж 16681 төл бойжиж, үүнээс 1002 төл хорогдсон байна. Мал төллөлт 62.9 хувьтай байна.

Том малын зүй бус хорогдол 4162 байна.

Сумын хэмжээнд мах 3, Гурил 2,8, будаа 1, гурилан бүтээгдэхүүн 0,2 сүү 0.2, өндөг 0.008, ургамлын тос 0.4, Төмс 1,8 тн, Хүнсний ногоо 0.4 тн, Элсэн чихэр 0.3 тн, Давс 0.3 тн, Савласан цэвэр ус 3 тн хүнсний бүтээгдэхүүний нөөцтэй байна. Дэлгүүрүүд ариутгал халдваргүйтлийн ажлыг хийж, халдвар хамгааллын дэглэмийг барьж ажиллаж байна.

Отрын 41 малчин өрхийн 27258 толгой мал отроор ирсэн байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн үлдэгдэлтэй нийт 47 зээлдэгчээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 36 зээлдэгчээс 1 иргэн зээлээ төлж хаасан байна. Үүнээс 17 зээлдэгчийн материалыг прокурорт шилжүүлэхээр бэлдэж байна. 5 иргэн зээлийн үлдэгдлээ сар бүр хуваарийн дагуу төлж барагдуулах хүсэлт гаргаад байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 45 хувьтай байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МЭРГЭЖИЛТЭН

Шивээговь сумын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэх “Орон сууцны 3,6,7,8-р байрны хаалга шинэчлэх” ажлын Тендерийг 2021 оны 04-р сарын 23 – ны өдөр /tender.gov.mn/-д цахимаар зарлаад байна.

Шивээговь сумын 2021 оны “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр хийгдэх “Орон сууцны 3,6,7,8-р байрны халаалтын шугамыг шинэчлэх /подволд халаалтын шугамыг хэсэгчлэн сольж узель засвар хийх/ гадна шугамыг засварлах ажлын үнэлгээний хороог байгуулж, техникийн тодорхойлолт болон тендерийн баримт бичгийг боловсруулж байна.

Мөн “Цэцэрлэгийг камержуулах” шууд худалдан авалтын ажилд 3 компани үнийн санал ирүүлсэн тул ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж Их зэст ХХК-ийг сонгон шалгаруулж 4 дүгээр сарын 27-нд гэрээ байгуулах мэдэгдэлийг хүргүүлээд байна.

МЭДЭЭ ГАРГАСАН:

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

О.БОЛОРМАА

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ